

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 09 сарын 04 өдөр

№ SR-2024-13

Улаанбаатар хот

ХасБанкны 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулсан цахим эчнээ санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь Банкны 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн R-2024-33 тоот тогтоолоороо хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Хагас жилийн ногдол ашигт нийт 18,948,600,000.00 (арван найман тэрбум есөн зуун дөчин найман сая зургаан зуун мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг зарлан хуваарилсугай.
- Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй тус Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 8 дугаар сарын 08-ны өдрийг Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
- Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр Банкны ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА